



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Монгол Улсын Дээд шүүхийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Х.Сонинбаяр даргалж, шүүгч Г.Алтанчимэг, П.Золзаяа нарын бүрэлдэхүүнтэй хийж, намын дарга шинээр сонгогдсоныг улсын бүртгэлд бүртгүүлэх, хаягийн бүртгэл хийлгэх талаар Улсын Дээд шүүхэд гаргасан Зон Олны намын ерөнхий нарийн бичгийн дарга Э.Батчимэгийн хүсэлтийг хянан хэлэлцэв

Шүүх хуралдаанд: хүсэлт гаргагч намыг төлөөлж Г.Эрдэнэтөгс, Э.Одбаяр, намын ерөнхий нарийн бичгийн дарга Э.Батчимэг, нарийн бичгийн даргаар Х.Билгүүн нар оролцов.

Зон Олны намын Ерөнхий нарийн бичгийн дарга Э.Батчимэгийн гарын үсэг бүхий хүсэлтэд: 1. “2020 оны 12 дугаар сарын 06-ны өдөр ЗОН-ын ээлжит Бага хурал зохион байгуулагдлаа. Тус хурлаар ЗОН-ын даргын албан тушаалаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан /ЗОН-ын дүрэм 36.3./ Г.Эрдэнэтөгсийн өргөдлийг хэлэлцэж, Бага хурлын гишүүдийн олонхийн саналаар хүсэлтийг зөвшөөрч шийдвэрлэлээ. Түүнчлэн ЗОН-ын ээлжит Бага хурлаар шинээр намын даргыг сонгох нууц санал хураалт явуулж /ЗОН-ын дүрэм 18.9.1./ Э.Одбаяр 81.8% саналаар намын даргаар сонгогдлоо. Иймд ЗОН-ын шинээр сонгогдсон намын даргыг бүртгэж өгнө үү. 2. УДШ-ийн цахим мэдээллийн санд ЗОН-ын холбогдох утасны дугаарыг 77001206 дугаарыг үлдээх /бусад дугаарыг хасах/, электрон шуудан [info@demos.mn](mailto:info@demos.mn) хаягаас гадна [secretary@demos.mn](mailto:secretary@demos.mn), [knowledge@demos.mn](mailto:knowledge@demos.mn) хаягуудыг нэмэх, вэб сайт [www.demos.mn](http://www.demos.mn) хаягаас гадна [www.zon.mn](http://www.zon.mn) хаягийг нэмэх, анх үүсгэн байгуулах баримт бичгийн тухай хэсэгт УДШ-ийн 2017.06.30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор бүртгэсэн намын дарга Эрдэнийн Одбаяр сонгогдсон тухай мэдээллийг оруулах, мөн Улсын бүртгэлийн гэрчилгээнд намын даргын өөрчлөлтийн бичилт зэрэг нэмэлт, өөрчлөлтүүдийг хийж өгнө үү.” гэжээ.

Хүсэлтэд Бага хурлын тэмдэглэл/х-3/, Зон олны намын бага хурлын гишүүдэд мэдэгдэл хүргүүлэх тухай /х-1/, намын дарга Г.Эрдэнэтөгсийн бага хуралд гаргасан өргөдөл /х-1/, Зон олны намын бага хурлын 2012/04 дугаар тогтоол /х-1/, Зон олны намын бага хурлын 2012/05 дугаар тогтоол /х-1/, Улсын бүртгэлийн гэрчилгээ эх хувь /х-1/, Зон олны намын бага хурлын /цахим/ ирцийн мэдээлэл, зураг /х-2/ зэрэг баримтуудыг ирүүлсэн байна.

Хүсэлтэд хавсаргагдсан дээрх баримт болон шүүх хуралдаанд өгсөн хүсэлт гаргагч талын тайлбарыг судлан хэлэлцээд ХЯНАВАЛ:

Зон Олны нам намын дүрмийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу намын ээлжит бага хурлыг 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хуралдуулжээ. Хурлыг цахимаар хийсэн баримтыг ирүүлсэн байна.

Тус нам үүсгэн байгуулагдах үеэс намын дүрэмдээ намын даргыг Бага хурлаас сонгох, Бага хурлын гишүүний тоо 33-261 гишүүнтэй байх, Бага хурал нь “намын даргыг нууц санал хураалтаар сонгох” эрхтэй болохыг заажээ. Тэрээр дүрэмд 2 удаа өөрчлөлт оруулж, Улсын дээд шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 02, 2019 оны 06

дугаар сарын 17-ны өдрийн 16 дугаар тогтоолоор дүрмийн өөрчлөлтийг бүртгэсэн байх ба намын даргыг сонгох намын Бага хурлын бүрэн эрхэд өөрчлөлт оруулаагүй, хэвээр байна.

Намын даргаар ажиллаж байсан Г.Эрдэнэтөгс намын даргын ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг намын Бага хурлын гишүүд хангаж, намын даргаар Э.Одбаярыг олонхийн саналаар буюу 81,8%-иар, нууц санал хураалтаар сонгосон болох нь 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хурлын тэмдэглэлд тусгагджээ. Зон Олны намын Бага хурлын 33 гишүүнээс хуралд 31 гишүүн оролцсон ба хурлын ирц 93.9%-тай байжээ.

Зон Олны намын даргад 1 хүн нэрээ дэвшүүлж, нууц санал хураалтын дүнгээр Э.Одбаяр 81,8%-ийн саналаар намын даргаар сонгогдсон болох нь хүсэлтэд хавсаргаж ирүүлсэн баримтаар тогтоогдсон байна.

Зон Олны намын ээлжит Бага хурлаар намын даргыг шинээр сонгох асуудлыг хэлэлцсэн, санал хураасан явц нь хууль болон намын дүрмийн зохицуулалтад нийцсэн байх тул намын шинээр сонгогдсон даргыг намын бүртгэлд тусгах боломжтой гэж үзлээ.

Мөн Зон олны намаас хаягийн өөрчлөлт бүртгүүлэхээр ирүүлснийг шийдвэрлэх нь зүйтэй байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8., 11.1.10., 11.3.-т заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1.Зон Олны намын Бага хурлын 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар намын даргаар Боржигин Эрдэнэ овогтой Эрдэнийн Одбаярыг /РД: ЧЛ87102071/ сонгогдсон болохыг улсын бүртгэлд бүртгэсүгэй.

2. Зон олны намын 77001206 дугаараас бусдыг хасч, электрон шуудан [secretary@demos.mn](mailto:secretary@demos.mn), [knowledge@demos.mn](mailto:knowledge@demos.mn) хаягуудыг, вэб сайт [www.zon.mn](http://www.zon.mn) хаягийг нэмж цахим бүртгэлд оруулсугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

ШҮҮГЧИД

Х.СОНИНБАЯР

Г.АЛТАНЧИМЭГ

П.ЗОЛЗАЯА